

МОНГОЛЫН ХИЙГЭЭД ХАСАГ ЦЭРГИЙН “ЛА’ВА”

Ж.Базарсүрэн.

Батлан хамгаалахын их сургуулийн профессор, доктор

Өгүүллийн товч утга: Эл өгүүлэлд орос тэргүүтэн улс орныхон “Монголын ла’ва” хэмээн нэрийдэж асан байлдааны журам нь дундад эртний монголын “Манлай” цэргийн зохион байгуулалтаас үүдэлтэй хийгээд мөн “Ла’ва” гэдэг нэр томъёо нь монголын “Ав”, Авлав” гэдэг үгнээс гаралтай болох тухай дуртгав.

Түлхүүр үг: Ла’ва, ав, авлав, облава, манлай цэрэг, байлдах арга байлдааны журам, тэргүүн анги салбар, дэмжих хүчин

Халимагийн эрдэмтэн Эренжен Хара-Даван Оросын хасаг (Казак) цэргийн байлдааны нэгэн алдарт аргын тухай өгүүлэхийн ялдамд түүнийг зөвхөн “Бледная копия Монгольской ла’вы” (Монголын “Ла’ва”-гийн бүдэгхэн хуулбар)¹ хэмээсэн байх бөлгөө. Гэтэл бид түүний тухай огт сонсож мэдээгүй асан тул “эртний монгол цэргийн дайралт галт уулын хайлмаг лаав мэт тасралтгүй үргэлжилдэг байсан учир оросууд тийн нэрлэсэн юм болов уу” хэмээн таамаглах төдий байсаар өдийг хүрэв. Гэвч нягталваас галт уулын хайлмагтай холбоогүй ажээ. Тэгвэл тэрхүү “Ла’ва” хэмээх нь чухам юу байж вэ гэдэг асуулт гарч ирнэ. Тэр тухай өгүүлсү.

Нэг. Хасаг цэргийн “Ла’ва”

Оросын хасагийн морьт цэргийн таруу жагсаалаар тулалдах байлдааны нэгэн төрлийн журам буюу гол төлөв дайсныхаа хоёр жигүүр, ар хударгаар ороох, байлдааны эгнээ журмыг нь алдагдуулах зорилготой тактикийн ажиллагааны өвөрмөц аргыг оросууд “Ла’ва” гэж нэрлэдэг² байв.

Оросын хасаг цэрэг Ла’ва-г нүүдэлчдээс уламжлан авсан агаад ХҮII зуунаас эхлэн түгээмэл хэрэглэх болсон гэх бөгөөд 1912 оноос Оросын армийн морьт цэргийн бүхий л анги салбарт хэрэглэх болжээ. Зөвхөн хасаг, орос цэрэг ч гэлтгүй Дагуурт байсан монголын морьт цэрэг ч ла’ва-гаар журамлан тулалддаг байсан тухай баримт бий³.

Морьт цэргийн бригад, хороо, зуут (суман)-ыг “Ла’ва”-гаар зохион байгуулахдаа

1. тэргүүн анги салбар;

2. дэмжих хүчин

гэж үндсэн хоёр цувраанд хуваадаг байжээ (Зураг 1). Жишээ нь: Зуутыг ла’ва-гаар журамлах үед тэргүүн эгнээнд тус бүр 10-16 хүнтэй хагас салаад буюу 6-7 хэсэг болгосон багуудыг томилон үүрэг гүйцэтгүүлдэг. Тэдгээр хэсэг тус бүр нь бие даасан байлдааны үүрэг хүлээж хэсэг, хэсгээрээ баг болон бөөндүү явах авч шаардлагатай үед зуутын захирагчийн тушаалаар нэгэн зэрэг юмуу эсвэл дэс дараалан тарж нэгэн эгнээ дэлгээ жагсаалын хэлбэрт шилждэг. Тэгэхдээ хэсэг бүрийн хооронд 50 хүртэл алхам, цэрэг бүрийн хооронд 5-10 алхмын завсартай байна.

Тэргүүн эгнээний ард 50-100 алхмын зайд 20-30 хүнтэй салаа хүртэл бүрэлдэхүүнтэй “Маяк” (Цамхаг) хэмээх хүчийг дэмжлэг болгон томилон байрлуулдаг. Тэрхүү дэмжих хүчин нь байлдааны журмын гүнээс галаар дэмжлэг үзүүлэх, мөн чухал цэгүүдэд гэнэтийн цохилт хийх үүрэгтэй байсан байна.

Хорооны ла’ва нь бие даасан 4-5 зуутын ла’ва болон 2-4 зуут хүртэлх хүчтэй “Маяк”-аас бүрдэнэ. Түүнээс гадна тагнуул, халхлан хамгаалах үүрэг бүхий тэргүүний зуутыг заавал томилон гаргадаг байв.

II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

Бригад, дивизийн ла'ва-г зохион байгуулахдаа хорооны ла'ва-гийн зарчмаар журамладаг.



Зураг 1. Хасагийн "Лава"

Тэр үеийн "Хасаг цэргийн ангиудыг ла'ва-гаар ажиллуулах дүрэм"-д дурдсаныг үзэхүл "Ла'ва" нь доорх гол хэдэн үүргийг гүйцэтгэдэг байжээ⁴. Үүнд:

1. хүчжүүлсэн тагнуул хийх;
2. дайсны талаас гүйцэтгэж болзошгүй тагнуулын ажиллагаанд саад учруулах;
3. гол хүчнийхээ хувьсах хөдөлгөөнийг (маневрыг) халхлах;
4. дайсныг сатааруулж анхаарлыг сарниулах...мөн мэхлэн дагуулж явсаар гол хүчнийхээ цохилтонд өртүүлэх;
5. ухарсан дайсныг мөрдөн хөөх;
6. дайсны зах сэжүүрээр ороон тойрох, бүслэх боломж бүрдүүлэх.

Ла'ва-г байлдааны бусад журамтай харьцуулахад дор дурдсан давуу талтай байна. Үүнд:

- дайсны морьт болон явган цэргийн аль алиных нь эсрэг хэрэглэхэд ихээхэн үр дүнтэй байдаг;
- зөвхөн дайрч довтлох хэрэглэгдэхүүн буюу дайралт, тулгарах байлдаанд морьт цэргийн хэрэглэдэг байлдааны гол журам болоод зогсохгүй явгалан хориглолт хийх үед ч үр ашигтай аргын нэг болдог;
- Лава нь таруу жагсаалаар зохион байгуулагддаг тул бие биесийн шил дарсан нягт шигүү эгнээнүүд бүхий байлдааны журамтай жишихэд дайсны галд өртөх магадлал харьцангуй бага учир хүн, хүчний хохирол үлэмж бага гардаг;

- Ар, өвөр, аль ч эгнээнээс хүн нэг бүрийн зэвсэг хэрэглэхэд эрсдэл багатай, тухайлбал илд сэлмээр цавчилдах үед хажуугийн хүндээ саад учруулдаггүй, арын эгнээнээс буудлага үйлдэхэд урдах эгнээнийхэнд аюул учруулах магадлал бага;
- гүн, шигүү жагсаал бүхий байлдааны журамтай харьцуулвал эгнээ жагсаалыг нөхөн сэргээхэд цаг хугацаа ихээхэн бага ордог;
- байлдааны журмынх нь бүтэц энгийн, уян хатан, тулалдааны явцад хөдөлгөөний чиглэлийг өөрчлөн хувьгах хийгээд дайсны фронтын хоёр жигүүрээр хялбар ороон тойрох боломж олгодог;
- ла'ва-гаар тулалдах арга, журамд бие бүрэлдэхүүнийг сургахад нэг их хүчин чармайлт гаргах, сургалтын тусгай арга хэрэглэх шаардлагагүй гэх мэт...

Тэгээд ч тухайн цагт ил задгай газарт дайралт хийх үед хүн, хүчний хохирол хамгийн бага байх боломж олгодог цорын ганц шалгарсан арга нь "Ла'ва" байсан учир зохион байгуулалтын үндсэн зарчмыг нь явган цэрэгт ч хэрэглэх болсон байна. Тухайлбал, таруу жагсаалд тулгуурласан явган цэргийн алдарт "Гинжинд тарах" арга нь чухамдаа түүнээс үлгэрлэн авсан зүйл гэнэм.

Хоёр. "Ла'ва" хэмээх нэрийн тухайд

Ла'ва гэдгийг зарим судлаач Италийн "Laṽa" буюу хөдлөгч цул (масс)⁵, эсвэл түрэгийн "Laṽa" гэх мэт үгнээс үүссэн гэх боловч ихэнх судлаач "Обла'ва" хэмээх орос нэр үгтэй холбон тайлбарласан байна. Тухайлбал он цагийн эрхээр уг үгийн эхний "Об" хэсгээс үе гээгдэн "Ла'ва" нь үлдэж хоцорсон хэмээнэ. Эл "Облава" нь монголоор "Ав хоморго", "Хомроглон баривчлах", "Бүслэн баривчлах" гэсэн утгатай үг⁶. "Орос хэлний тайлбар толь"-д:

1. Охота, при которой окружают место, где находится зверь, и затем гонят его на стрелков (ан гөрөөс байгаа газрыг бүслэн хаагаад дараа нь түүнийг анчид руу турхиран хөөж аваачдаг ав);
2. Оцепление места, где находятся или могут находиться преследуемые лица, с целью их поимки (мөрдөн хөөгдөж буй этгээдүүдийг баривчлах зорилгоор тэдний орогнон буй юмуу байж болзошгүй газрыг бүслэн хаах) гэж тайлбарлажээ⁷.

Харин үгийн гарлын хувьд "Облава" гэдгийг Оросын голдуу судлаачид эртний түрэгийн "Abla"⁸-гаас үүдэлтэй хэмээжээ. Гэтэл монгол хэлэнд эл үг нь мөн яг тэр "Ab (ав), abla (авла)" хэмээх утга, хэлбэрээрээ байсаар байгаа билээ. Оросууд "Обла'ва" гэж бичих авч "Абла'ва" гэж дууддаг нь ч бас нэгийг өгүүлж буй хэрэг буюу.

"Ав" хэмээх язгуураас "Авлах", "Авлав" гэх мэт ан гөрөө хийх, авлахтай холбоотой олон үг, нэр томъёо үүсдэг. Жишээ нь, "Ав хоморго", "Хүрээ ав" буюу "Хоморгот ав", "Зээгт ав", "Дэлгүү ав", "Хайдаг ав" "Ав хавчуур" гэх мэт. Гэхдээ "Ав" нь гагц ан гөрөөтэй холбоотой ч үг биш. "Гучин зургаат тайлбар толь"-д "Олныг авч гөрөөс, шувууг харван намнаж, **цэргийн эрдмийг боловсруулахуйг ав хэмээмүй**" гэжээ⁹. "Ав хавчуур цэрэг" хэмээх тусгай томилолтын цэргийг тухайлсан нэр томъёо ч бий¹⁰.

Ер нь гагц эл үг төдийгүй эртний монгол цэргийн өөр олон нэр томъёо, байлдах, дайлах арга ухаан чухам ан автай холбоотой байдгийг дуртгах нь илүүц биз.

Тэр бүхнийг эс өгүүлэн өгүүлвээс, дээрх **"Ла'ва" хэмээх нь монгол-түрэгийн "Ab", "Abla", улмаар "Ablaba" (авлав) гэдгээс үүдэлтэй нь тодорхой байна.**

Гурав. Монголын ла'ва


Хасаг цэргийн "Ла'ва"-гийн үүтгэл болсон "Монголын ла'ва" гэж чухам юу байв? Эл асуултанд хариу олохын тулд Эренжен Хара-Дава-гийн өгүүлснийг тунгаан шүүрдэх нь зүй буй за. Тэрбээр "...монголчуудын хүнд морьт цэрэг маневрлах чадвар ихээхэн сайтай байсны дээр хөнгөн морьт цэрэг нь байлдаанд маш идэвхитэй үүрэг гүйцэтгэдэг байснаас бус хоёрдугаар зэргийн үүрэгтэй оролцдог байсангүй. Хүнд морьт цэрэг нь дайсныхаа байрлалын аль нэгэн хэсэгт сүйрлийн цохилт хийхээр зогсохгүй бас жигүүр рүү нь түрэх, мөн түүнчлэн ар хударганд нь ч гарч довтлох чадвартай байв. Ингэж шуурхай маневрлах чадавхтай байсны ачаар гол цохилт хийх чиглэл, цэгийг заавал урьдчилан товлох шаардлага ч гардаггүй байсан бөгөөд тулалдааны явц дунд бий болсон нөхцөл байдалтай уялдуулан тодорхойлох боломжтой байсан ажээ. Харин **хөнгөн морьт цэрэг нь зөвхөн тагнан турших, халхавч болох төдийгүй гол нь төлөвлөгдөж буй шийдвэрлэх цохилтын идэвхтэй бэлтгэлийг хангах үүргийг гүйцэтгэдэг байв. Энэ нь мөнөөх алдарт "Монголын ла'ва" байлаа. Тэр ажиллагаа нь магадтай түүний бүдэгхэн хуулбар төдий болох манай хасаг цэргийн ла'ва-тай төстэй байсан авч хасагуудынх лугаа адил ганц эгнээгээр бус, харин шил дарсан хэд хэдэн (тав хүртэл) таруу эгнээгээр дайрдаг. Тэгэхдээ эхний эгнээний сумаа харваж дууссан юмуу жагсаалаас гарсан дайчны оронд арын эгнээнүүдээс нь нөхвөрлөн орж тулалддаг байжээ**" гэжээ¹¹.

Эрэнжин Хара-Даваны энэ тодорхойлолтоос ажиглагдаж буй гол онцлог зүйлүүд гэвээс:

1. "Монголын ла'ва" хэмээх байлдааны журам нь шил дарсан хэд хэдэн давхар эгнээнээс бүрддэг байж;
2. эгнээнүүд нь нягт шигүү бус, харин таруу дэлгэмэл жагсаалаас бүрдэж байж;
3. арын эгнээнүүд нь өвөр эгнээнүүдээ нөхвөрлөдөг буюу нэг нэгнийхээ "нөөц хүч"-ний үүргийг давхар гүйцэтгэдэг;
4. "Ла'ва"-д багтагч нэгжүүд буюу анги, салбарууд нь өөрсдийн идэвхтэй үйл ажиллагаагаар гол чиглэлд шийдвэрлэх цохилт хийх нөхцөлийг гол хүчиндээ бүрдүүлж өгдөг;
5. тэдгээр нэгж нь мөн "Гол хүчин" буюу Э.Хара-Даваны тодорхойлсноор "Хүнд морьт цэрэг"-ийнхээ халхавч болдог;
6. бас тагнан турших ажиллагаа явуулдаг, өөрөөр хэлбэл "Байлдан тагнах" ажиллагаа зохион байгуулдаг байсан байна.

Гэтэл байлдан тагнах, гол хүчнийхээ халхавч болох, гол чиглэлд шийдвэрлэх цохилт хийх нөхцөлийг бүрдүүлэх зэрэг дээрх үүргийг дундад эртний үед их цэргийн гол хүчний өмнө явдаг "Манлай" хэмээх тусгайлан томилогдсон цэрэг гүйцэтгэдэг байсан билээ. Жишээ нь, 1204 онд Найманы Таян хаантай байлдсан Наху гүний тулалдаанд

II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ



Тэмдэглэл:



- Манлайн 1-р цувраа




- 2-р цувраа (Дайсны хоёр жигүүрээр тойрох, ар хударгаар довтлох үүрэг бүхий цэрэг)




- 3-р цувраа (Хошуу жагсаалаар довтолгч "Алгинч" цэрэг)



- Довтолгооны үндсэн чиглэл



- Эсрэг талын цэрэг



- Довтолгооны болзошгүй чиглэл

Зураг 2.

Манлай цэргийн байлдааны журам, маневрын хувилбар.
(Наху гүний байлдааны жишээн дээр 1204он)

Чингис хааны өөрийн биеэр удирдсан “Манлай” цэрэг нь лавтай гурван цувраанаас бүрдэж байсан бөгөөд тэдгээр цувраа бүр нь дотроо мөн бие даасан хэд хэдэн хэсгээс бүрдэж асан нь тодорхой байдаг. Тухайлбал:

- нэгдүгээр цувраанд буюу нүүрний эгнээнд Зэв, Хубилай, Зэлмэ, Сүбээдэй нарын удирдсан агаад тус бүр **бие даасан дөрвөн хэсэг** цэрэг дайсны эгц урдаас дайрч байхад,
- хоёрдугаар цувраа болох Урууд, Мангудын цэргийн мөн л тус бүр бие даасан **хоёр хэсэг** Найманы цэргийн байрлалын хоёр жигүүрээр ороон довтолгож,

- гуравдугаар цувраанд Чингис хаан хишигтэн цэргийнхээ хамт алгинчилсан буюу одоогийн хэллэгээр бол “Байлдан тагнах ажиллагаа” явуулсан байна. Хишигтэн цэрэг нь ч дотроо мөн хэд хэдэн цуваа, эгнээнээс бүрдэж байсан нь тодорхой.

Эндээс харахад эл тулалдаанд Чингис хааны манлай цэргийн цувраа, хэсэг бүрийн гүйцэтгэсэн үүрэг, бүтэц зохион байгуулалт нь Э.Хара-Даваны өгүүлсэн “Монголын ла’ва”-тай яг таарч буй нь хэнд ч ойлгомжтой байна. Харин Чингис хаан байлдах арга, зарчим, байлдааны журмаа тодорхойлохдоо “Харгана зорчил зорчиж, нуур бай(л)ду байлдаж, цүүц хатгаа хатгалдая!” хэмээн зарлиг болжээ¹².

Энд өгүүлэн буй “Харгана зорчил зорчих” гэдэг нь “Хэсэг хэсгээр бут сөөгөөр ургадаг харгана мэт цөөн цөөн хүнтэй олон хэсэг баг болж таруу жагсаалаар давших”-ыг хэлсэн хэрэг юм. Хасаг цэргийн ла’ва-гийн тэргүүн эгнээ ч мөн энэ мэт болохыг дээр өгүүлсэн. Гэхдээ Чингис хааны манлай цэрэг хасагийнх шиг ганц эгнээ бус, харин гээг дарсан хэд хэдэн эгнээ буюу цувраатай байсныг мөн дурдсан.

Өөрөөр хэлбэл манлай цэргийн бие биесийн гээг дарсан эгнээ, цувраа бүр өмнөх цувраа, эгнээгээ дэмжигч, нөхвөрлөгч нөөц хүчин болж байж. Харин хасагийн ла’ва нь ардаа цөөн хүн бүхий ганцхан бүлэг дэмжих хүчин буюу “Маяк”-тай байснаараа ялгаатай байна.

“Нуур бай(л)ду (“байрт”. Ж.Б.) байлдах” гэж “цэргээ таруу байдлаар буюу аравт, зуутын хооронд харьцангуй их завсар, гүнтэйгээр жагсааж, нуур мэт өргөн дэлгэр байр эзлэн тулалдахыг хэлнэ. Ийнхүү “Нуур байр” хийж тулалдах явцдаа дайсныг аажмаар тал талаас нь бүслэн хааж, хэсэглэн хуваагаад нууранд живүүлэх адил сарниан устгадаг байна. Наху гүний тулалдаанд Урууд, Мангудын цэрэг дайсныхаа зах сэжүүрээр ороон тойрох үүргийг эхэлж гүйцэтгэжээ. Тэгвэл “Ла’ва”-гийн байлдаанд гүйцэтгэдэг байсан нэг үүрэг нь мөн л энэ мэт дайсныхаа хоёр жигүүрээр ороож бүслэн хаах ажиллагаа байв.

“Цүүц хатгаа хатгах” гэж юмыг цүүцдэх мэт дайсны цэргийн байлдааны журам, эгнээ жагсаалыг цөмлөн сэтлэхийг, өөрөөр хэлбэл гол чиглэлд хүч хуримтлуулан гэнэтийн цохилт хийхийг хэлнэ. Ийм цохилтыг манлай бус, харин гол хүчний анги, салбарууд хийдэг. Харин манлай цэрэг нь тийм нөхцөлийг бүрдүүлдэг буюу гол хүчнийхээ халхавч болж өгдөг байжээ. Ла’ва-ийн гүйцэтгэдэг асан нэг үүрэг бол мөн энэ мэт гол хүчнийхээ халхавч болох явдал байсан билээ.

Энэ бүхнээс үзвэл дундад эртний монгол цэргийн манлайн байлдааны журмаас үүдэлтэй “**Бие биесийн гээг дарсан хэд хэдэн эгнээ цувраа бүхий морьт цэргийн таруу жагсаалаас бүрдсэн байлдааны журам**”- ыг хожим нь орос тэргүүтэн өрнөдийнхөн “Монголын ла’ва” гэж нэрлэсэн болох нь илэрхий байна.

II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

Төгсгөл

Дээр өгүүлснийг нэгтгэн дүгнэвээс:

1. Ла'ва гэдэг нь монгол-түрэгийн "Ab-abla-ablab" гэдгээс гаралтай нэр томьёо болох нь илэрхий байна
2. Оросын хасаг цэргийн ла'ва нь эртний монголын ав хоморго буюу хүрээ авын арга хэлбэр, зарчим дээр үндэслэсэн, дундад эртний монголын манлай цэргийн байлдааны журмаас үүдэлтэй бөгөөд тийм зарчмаар зохион байгуулсан байлдааны журам, аргыг орос тэргүүтэн улс аймгийнхан хожим нь "Монголын ла'ва" хэмээн нэрлэх болсон байна
3. "Ла'ва" нь эртний монголчуудаас дэлхий дахины цэргийн урлагийн хөгжил, байлдах арга ухаанд оруулсан олон шинэлэг зүйл, хувь нэмрийн нэг байжээ хэмээнэ.

Эш татсан ном

-
- ¹ Эренжен Хара-Даван. Чингис хан-как полководец и его наследие. Элиста. 1991 г. 76 дахь тал.
 - ² Военный энциклопедический словарь в двух томах. Москва. 2001. Т-1. 812 дахь тал.
 - ³ Словарь русского языка. Т-II. Москва. 1983. 158 дахь тал.
 - ⁴ Казачья лава. <http://www.Kyrgyz.ru/forum/index.php?showtopic=2222>.
 - ⁵ Военный энциклопедический словарь в двух томах. Москва. 2001. Т-1. 812 дахь тал.
 - ⁶ Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. Орос Монгол толь. Улаанбаатар. 1982. 351 дэхь тал.
 - ⁷ Словарь русского языка. Т-II. Москва. 1983. 536 дахь тал.
 - ⁸ Древнетюркский словарь. Изд. "НАУКА". Ленинград. 1969. 3 дахь тал.
 - ⁹ Марал овогт Сумьяабаатар. Гучин зургаат тайлбар толь. I-IV. Есдүгээр дэвтэр. Цэргийн гүнгийн хураангуй. Ав аяны зүйл. Улаанбаатар. 2005 он. 259 дэхь тал.
 - ¹⁰ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Улаанбаатар. 2008 он. I боть. 12 дахь тал.
 - ¹¹ Эренжен Хара-Даван. Чингис-хан как полководец и его наследие. Элиста. 1991. с 73-74.
 - ¹² Сумьяабаатар Б. Монголын нууц товчоо. Үсгийн галиг. Улаанбаатар. 1990 он. 489 дэхь тал.